



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2023/157/А/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Ховд хот
2023 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Хоо өрлөгийн үрс аудит ХХК
Аудитор: А.Оюундэлгэр
Утас: 99306289
цахим хаяг: a_oyund@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.5.3 Нэмэлт төсөв	13
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Залруулсан алдаа.....	15
<i>Үндсэн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй</i>	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар



ҮЕНЧ СУМЫН ХҮҮХДИЙН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Т.ТОГТОХБАЯР ТАНАА

**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.14 № 02/37
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үенч сумын Хүүхдийн цэцэрлэг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгосон байна.

Багш нарын цалинг ТҮБД-4 ангиллаар олгосон, хувьсах зардлын тухайд багшийн эрүүл мэндийн үйлчилгээ, дата хэрэглээний зардал, хичээл практикийн зардал, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн зардлыг тусгаж, төлөвлөх, зарцуулах аргачлалыг Засгийн газрын 2022 оны 91 дугаар тогтоолоор баталж мөрдсөн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг Тус сургууль нь 2022 онд нийт 230 хүүхэд сургах хүчин чадалтайгаас гүйцэтгэлээр 250 хүүхэд сургуулийн боловсролд хамруулж биелэлт 108.6 хувьтай байна.

021020243

Тус байгууллага нь тайлант онд 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 100.0 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. “

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,635,826.40	38,064,868.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	267,388.90
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	267,388.90
3121	Төгрөг	00.00	267,388.90
31211	Төрийн сангийн харилцах		
33	АВЛАГА	7,848,368.00	3,086,293.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,062,106.00	2,162,106.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	676,887.00	676,887.00
335	Бусад авлага	5,109,375.00	247,300.00
3351	Байгууллагаас авах авлага	5,109,375.00	247,300.00
35	БАРАА МАТЕРИАЛ	32,787,458.40	34,711,186.40
351	Түүхий эд материал	27,254,386.40	26,254,286.40
35110	Тусгай зориулалттай материал	26,254,286.40	26,254,286.40
35130	Эм боох материал	1,000,100.00	00.00
354	Хангамжийн материал	5,533,072.00	8,456,900.00
35410	Бичиг хэргийн материал	70,000.00	00.00
35460	Хүнсний материал	4,588,672.00	5,215,800.00
35470	Бусад хангамжийн материал	874,400.00	3,241,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	908,713,955.72	886,787,462.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	908,713,955.72	886,787,462.63
392	Биет хөрөнгө	896,713,955.72	874,787,462.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	878,469,411.83	878,469,411.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29,589,150.19	-51,646,650.75
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,208,451.00	36,451,521.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,741,820.92	-27,257,703.96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,459,271.67	65,415,267.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,464,510.67	-33,626,884.32
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,396,023.00	9,396,023.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,168,008.00	-5,637,809.20
39217	Ном	3,144,288.00	3,224,288.00
393	Биет бус хөрөнгө	12,000,000.00	12,000,000.00
39301	Програм хангамж	198,432.00	198,432.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-198,432.00	-198,432.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,000,000.00	12,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	949,349,782.12	924,852,330.93
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,318,367.89
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,318,367.89
413	Өглөг	00.00	1,318,367.89
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,318,367.89
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	949,349,782.12	923,533,963.04
51	Засгийн газрын хувь оролцоо	949,349,782.12	923,533,963.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	122,504,224.00	122,504,224.00
51101	Өмч: - төрийн	122,504,224.00	122,504,224.00
512	Хуримтлагдсан үр дүн	453,264,307.12	427,448,488.04
51210	Өмнөх үеийн үр дүн	453,264,307.12	453,264,307.12
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-25,815,819.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	373,581,251.00	373,581,251.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	949,349,782.12	924,852,330.93

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	593,672,692.00	605,521,513.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	127,000,000.00	7,223,013.00
120	Нийтлэг татварын бус орлого	127,000,000.00	7,223,013.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	127,000,000.00	7,223,013.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	127,000,000.00	7,223,013.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	44,662,792.00	77,720,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	42,244,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	42,244,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	422,009,900.00	520,578,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,688,512.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,688,512.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,412,400.00	35,475,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,412,400.00	35,475,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,561,880.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,561,880.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	481,983,897.52	631,337,332.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	481,983,897.52	631,337,332.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	434,329,830.23	615,728,973.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,558,563.00	373,891,110.62
210101	Үндсэн цалин	302,005,888.00	373,891,110.62
210102	Нэмэгдэл	3,552,675.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,775,319.11	45,735,235.37
210201	Тэтгэврийн даатгал	38,775,319.11	45,735,235.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,843,949.60	57,557,899.30
210301	Гэрэл, цахилгаан	2,177,649.60	3,197,300.00
210302	Түлш, халаалт	24,633,000.00	54,360,599.30
210303	Цэвэр, бохир ус	33,300.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,566,618.00	528,000.00
210401	Бичиг хэрэг	124,600.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,195,500.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	87,200.00	00.00
210404	Ном, хэвлэл	20,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	863,368.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	275,650.00	00.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	528,000.00
2105	Нормативт зардал	27,495,770.02	85,591,722.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	398,650.00	1,000,100.00
210502	Хоол, хүнс	26,409,620.02	84,591,622.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	687,500.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	182,000.00	00.00
210604	Урсгал засвар	182,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	790,400.00	1,109,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,400.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	522,000.00	00.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,109,500.00
210807	Газрын төлбөр	214,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,117,210.50	51,315,506.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,995,300.00	17,264,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,287,350.00	4,821,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,834,560.50	29,229,506.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,654,067.29	15,608,358.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,387,024.00	14,520,400.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,561,880.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,825,144.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	14,520,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,267,043.29	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,267,043.29	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,087,958.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,087,958.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	111,688,794.48	-25,815,819.08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	111,688,794.48	-25,815,819.08

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,504,224.00	373,581,251.00	453,264,307.12	949,349,782.12
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,504,224.00	373,581,251.00	453,264,307.12	949,349,782.12
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,504,224.00	373,581,251.00	453,264,307.12	949,349,782.12
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-25,815,819.08	-25,815,819.08
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,504,224.00	373,581,251.00	427,448,488.04	923,533,963.04

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	466,672,692.00	598,298,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	466,672,692.00	598,298,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	42,244,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	42,244,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	422,009,900.00	520,578,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,688,512.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,688,512.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,412,400.00	35,475,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,412,400.00	35,475,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,561,880.00	00.00

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,561,880.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	466,672,692.00	598,031,111.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	466,672,692.00	598,031,111.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	419,018,624.71	582,422,752.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305,827,121.11	364,423,203.10
210101	Үндсэн цалин	188,330,036.00	282,931,870.49
210102	Нэмэгдэл	95,963,478.11	59,256,603.06
210104	Урамшуулал	21,533,607.00	22,234,729.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,616,136.00	49,122,700.00
210201	Тэтгэврийн даатгал	29,249,650.00	33,588,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,078,900.00	3,850,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,463,120.00	3,141,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	615,780.00	751,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,208,686.00	7,791,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,230,299.60	57,957,899.30
210301	Гэрэл, цахилгаан	3,197,299.60	3,197,300.00
210302	Түлш, халаалт	24,633,000.00	54,360,599.30
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,464,468.00	00.00
210401	Бичиг хэрэг	117,600.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,069,600.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	99,800.00	00.00
210404	Ном, хэвлэл	57,600.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	863,368.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	256,500.00	00.00
2105	Нормативт зардал	26,505,300.00	85,746,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,173,000.00	00.00
210502	Хоол, хүнс	24,639,000.00	85,746,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	693,300.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	182,100.00	1,180,000.00
210604	Урсгал засвар	182,100.00	1,180,000.00
2107	Томилолт, зочны зардал	125,900.00	00.00
210702	Дотоод албан томилолт	125,900.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	717,400.00	1,109,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	573,800.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,109,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,349,900.00	22,882,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,300,000.00	18,189,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,049,900.00	4,692,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,654,067.29	15,608,358.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,387,024.00	14,520,400.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,561,880.00	00.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,825,144.00	00.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	14,520,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,267,043.29	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,267,043.29	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,087,958.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,087,958.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	267,388.90
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	267,388.90
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	267,388.90

2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	603,135,700.00	535,302,683.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	603,135,700.00	535,302,683.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	588,615,300.00	520,782,283.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	370,819,000.00	359,149,911.10
210101	Үндсэн цалин	304,721,600.00	277,098,780.49
210102	Нэмэгдэл	54,763,100.00	64,811,123.06
210104	Урамшуулал	11,334,300.00	17,240,007.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,680,400.00	51,977,322.00
210201	Тэтгэврийн даатгал	33,967,600.00	32,132,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,885,700.00	3,713,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,185,600.00	2,969,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	760,500.00	5,712,122.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,881,000.00	7,449,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,095,300.00	00.00
210301	Гэрэл, цахилгаан	3,197,300.00	00.00
210302	Түлш, халаалт	54,498,000.00	00.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	00.00
2105	Нормативт зардал	85,838,100.00	85,662,850.00
210502	Хоол, хүнс	85,838,100.00	85,662,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	182,100.00	00.00
210604	Урсгал засвар	182,100.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,110,000.00	1,109,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,110,000.00	1,109,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22890400.00	22882700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,690,400.00	18,189,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,200,000.00	4,692,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14520400.00	14520400.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	14,520,400.00	14,520,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,520,400.00	14,520,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	520,578,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	520,578,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	520,578,500.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	267,388.90
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30	30
620001	Удирдах ажилтан	2	2
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17
620003	Үйлчлэх ажилтан	11	11

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

2021-2022 оны хичээлийн жилд “Хүүхдийн нийгэм, сэтгэлзүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж сурах тэгш боломжийг бүрдүүлэх хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт үйл ажиллагааг чанар үр дүнтэй зохион байгуулах хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэх зорилгыг дэвшүүлж оролцоог хангахад анхаарч ажилласан байна. Танхимын сургалтаар 8 бүлэгт 2-5 насны 225 хүүхдийг хамруулан СӨБ олгон ажилласан ба тус хичээлийн жилд 5 настай 65 хүүхэд 4 настай 68 хүүхдийг хувилбарт сургалтад хамруулахаар төлөвлөн малчин өрхийн Нарийн гол багийн 20 хүүхдэд багийн дарга нартай хамтран багш нарын боловсруулсан дасгал даалгаврыг өгч гэрээр нь ажилуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөдөлмөрийн тухай, Боловсролын тухай, сургуулийн өмнөх боловсролын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай багц, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай 91 дугаар тогтоол, Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ тогтоох 107-р тогтоол, МУ-ын БШУ-ны сайдын А/122 тушаал, МУЗГазрын 192 дугаар тогтоол, Сангийн сайдын 120 дугаар тушаал, МУЗГазрын 252 дугаар тогтоолыг тайлант онд мөрдөж ажилласан байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн

тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд:

Ховд аймгийн Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24.4 сая төгрөгөөр буюу 9.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		267,3	267,3
Авлага	7,848,3	3,086,2	-4762,1
Бараа материал	32,787,4	34711,1	1923,7
Үндсэн хөрөнгө	908,713,9	886,787,4	-21,926,5
Нийт хөрөнгө	949,349,6	914,852,0	-34,497,6
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	949,349,7	923,533,9	-25,815,8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	949,349,7	924,852,3	-24,497,4

✓ Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс харахад үндсэн хөрөнгө 24,4497,4 мянган төгрөгөөр авлага 4,762,1 төгрөгөөр буурч, мөнгөн хөрөнгө 267,3, бараа материал 1,923,7 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 365.5 сая, орон нутгийн төсвөөс 108.6 сая нийт 474.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 30.1 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Энэ нь МУЗГ-ын 2022 оны 91 тоот тогтоолоор хувьсах зардлын санхүүжилтийг хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь тооцож, батлагдсан хуваарьт нийцүүлэн сар бүр

сургалтын байгууллагад олгож байгаа, нэг хүүхдэд ногдох зардлын дундаж нормативаар олгох санхүүжилтийн гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж хагас, бүтэн жилээр тооцон, зохих өөрчлөлтийг тусган төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн шийдвэрээр санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 154.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 154.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 598.2 сая төгрөгийг улс, орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 596,8 сая төгрөгийн санхүүжилт олгож, Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 596,8.0 сая төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл
/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	2101	370,819,0	359,428,4	11,390,5	96,9
2	2102	49,680,4	54,117,4	-4,437,0	108,9
3	2103	58,095,3	57,957,8	137 -	99,7
4	2105	85,838,1	85,662,8	175,2	99,8
5	2108	1,110,0	1,109,5	0,5 -	100
6	2109	22,890,4	22,882,7	7,7 -	100
	Дүн	588,433,2	581,158,6		

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт төсөвтэй холбоотой нэмэлт дансаар ямар нэгэн гүйлгээ гараагүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хоо өрлөгийн үрс аудит ХХК-ийн захирал, аудитор А.Оюундэлгэр 2023 оны 1 дүгээр сарын 23 -нээс 2023 оны 02 дүгээр сарын 14 -ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2023 оны 01 дүгээр сарын 24 өдрийн 04 албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн тайлангийн нийт орлого 593.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 11.8 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоосон шалтгаан нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоор тогтоосонтой холбоотой байна.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээллийг хугацаандаа оруулж 15 мэдээ хугацаа хоцорч шилэн дансны сайтад байршуулсан байна.

4. Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	5.1	1	5.1	100
Албан шаардлага					
Зөвлөмж	4	7.6	2	7.6	100
Нийт дүн	5	12.7	3	12.7	100

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6.0 сая төгрөгийн алдаа¹, өглөг авлагыг тооцоо бүрэн хийгээгүй, цалин хөлсний тооцоо программын алдаанаас зөрсөн зэрэг алдаа илэрлээ. Үүнд:

- ✓ Мөнгөн хөрөнгийн журналыг өглөг авлагын дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад НДШ -ийн өглөг 0.9 сая төгрөг, урьдчилгаа 0.1 авлагаар тусгаагүй, Төрийн аудитад 0.2 сая төгрөг илүү төлсөн авлагаар бүртгээгүй, ҮЭ-ийн татвар 0.2 сая төгрөгийг илүү шилжүүлснийг авлагаар тусгаагүй нийтдээ 1.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5. дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 15.2. Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна гэсэн заалтыг үндэслэн залруулга хийв.
- ✓ 5 Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийн тооцсон цалин үр дүнгийн тайлангийн өртөгт суусан цалингаас 4.6 сая төгрөгөөр зөрж санхүүгийн программын алдаа илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.2. Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна гэсэн заалтыг үндэслэн залруулга хийв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайланд тусгах, өр авлагын тооцоог үнэн зөв хийх, програмын алдааг засуулах	2	6.0			2	6.0	2	6.0				
Дүн	2	6.0			2	6.0	2	6.0				

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *Х.БОЧЕР* Х.БОЯДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: *А.ЦЭЦЭГСҮРЭН* А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

ХО ӨРЛӨГИЙН ҮРС АУДИТ ХХК-НЫ

АУДИТОР: *А.ОЮУНДЭЛГЭР* А.ОЮУНДЭЛГЭР

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.